

Оюутан суралцагчдад зөвлөмж

НЭГ. Бүртгэл, хичээл сонголт

- Бүх түвшний хичээл сонголтыг 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрөөс цахимаар зохион байгуулна.
- Магистрын хөтөлбөрт шинээр элсэгчдээс суралцах чиглэлийн дагуу мэргэжлийн ярилцлага болон гадаад хэлний мэдлэгээр шалгалт авна. Шалгалт авах өдөр, цаг болон шалгалттай холбоотой мэдээллийг бүртгэлийн хугацаанд цахим хуудсанд байршуулна.
- “Оюутны хөгжлийн зээл” болон “Буцалтгүй тусламж”-д хамрагдах болон сунгалт хийлгэх суралцдагчдын материалыг цахимаар 2022 оны 01 дүгээр сарын 17-ноос 01 дүгээр сарын 28-ны өдөр хүртэл хүлээн авна.
- 2021-2022 оны хичээлийн жилд мөрдөх 1 кредитийн үнэлгээ болон сургалтын төлбөр төлөх дансны мэдээллийг цахим хуудаснаас авна.

ХОЁР. Сургалтын үйл ажиллагаа

- 2021-2022 оны хичээлийн жилийн хаврын улирлын сургалт 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр явагдана.
- Суралцагчид хичээл бүрийн удирдамжтай сайтар танилцаж, хичээлийн хуваарийн дагуу танхимын болон танхимын бус сургалтад идэвхтэй оролцоно.
- Цахим хичээлд LMS платформ болон Microsoft Office 365-Teams програм ашиглана.
- Цахим хичээлд хэрэглэх ном сурах бичиг болон бусад материалыг ашиглахад номын санчаас нэвтрэх код авч, must.lib4u.net электрон каталогийн хаягаар нэвтрэнэ.

ГУРАВ. Оюутны дотуур байрны үйл ажиллагаа

- Дотуур байртай холбоотой зарыг ШУТИС-ийн цахим хуудсаар мэдээлж, дотуур байранд суух хүсэлтийг цахимаар хүлээн авна.
- Дотуур байранд орох бүртгэл нь баталгаажсан оюутан, суралцагчийг танхимын сургалт эхлэхээс өмнө хүлээн авна.
- Дотуур байранд халдвар хамгааллын дэглэмийн талаар мэргэжлийн байгууллагаас өгсөн заавар, зөвлөмжийг баримтлана.

Сургалтын бодлого зохицуулалтын газар